



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий
мэргэжилтэн, гишүүд, зөвлөлийн ажиллах
журмыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын бодлого тодорхойлох, Эрүүл мэндийн тухай хууль, тогтоомж, журмын хэрэгжилтийг хангахад мэргэжлийн дэмжлэг үзүүлж, зөвлөж ажиллах чиг үүрэг бүхий Эрүүл мэндийн яамны орон тооны бус “Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Мэргэжлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мэргэжлийн салбар зөвлөлийг шуурхай удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, тайланд хагас бүтэн жилээр үнэлгээ өгч ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/266 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 01 сарын 02 өдрийн
А/01 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

№	Нэрс	Албан тушаал		Зэрэг, цол
1) Арьс судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Б.Хандсүрэн	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУҮИС-ийн Арьс судлалын тэнхимийн багш	АУ-ны доктор, дэд профессор
2.	Ц.Сарангуа	Нарийн бичгийн дарга	АӨСҮТ-ийн эмчилгээний гоо сайхан, нөхөн сэргээх тасгийн эмч	АУ-ны доктор
3.	Х.Алтанзул	Гишүүн	“Гран при” эмнэлгийн зөвлөх эмч	АУ-ны доктор
4.	Б.Дашлхүмбэ	Гишүүн	АШУҮИС-ийн Арьс судлалын тэнхимийн багш	АУ-ны доктор
5.	Д.Дэлгэрцэцэг	Гишүүн	Цэргийн төв эмнэлгийн арьс гоо заслын их эмч	АУ-ны магистр
6.	Г.Цогзол	Гишүүн	АӨСҮТ-ийн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч
7.	Я.Энхтөр	Гишүүн	АШУҮИС-ийн Арьс судлалын тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор, дэд профессор
2) Гэмтэл согог судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	С.Отгонгэрэл	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	ГССҮТ-ийн зөвлөх эмч	АУ-ны магистр, профессор, зөвлөх зэргийн эмч
2.	А.Эрдэнэбилэг	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн Гэмтэл согог судлалын тэнхимийн эрхлэгч	АУ-ны магистр
3.	С.Баатаржав	Гишүүн	ГССҮТ-ийн Эрдэм шинжилгээ сургалтын албаны дарга	АУ-ны доктор, дэд профессор
4.	Б.Батзориг	Гишүүн	ГССҮТ-ийн Яс үений гэмтлийн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч
5.	Т.Баянхүү	Гишүүн	“Ортопед” эмнэлгийн захирал	АУ-ны доктор
6.	М.Болдбаатар	Гишүүн	ГССҮТ-ийн хүүхдийн гэмтэл согогийн 1-р тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
7.	Б.Бүргэд	Гишүүн	ГССҮТ-ийн зөвлөх эмч	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч

8.	Э.Галбадрах	Гишүүн	ГССҮТ-ийн Түлэнхийн Нөхөн сэргээх мэс заслын тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
9.	Т.Сүхбаатар	Гишүүн	Цэргийн төв эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч
3) Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл				
1	С.Сонин	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны ерөнхийлөгч	АШУ-ны доктор, профессор
2	Д.Мягмарцэрэн	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн Өрхийн анагаах ухааны тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор
3	С.Батсэрээдэнэ	Гишүүн	“Этүгэн” сургуулийн захирал	АУ-ны доктор
4	Ц.Ганхүү	Гишүүн	Сумын эмнэлгүүдийн холбооны тэргүүн	АУ-ны магистр
5	Б.Оргил	Гишүүн	“Ач” АУДС-ийн дэд захирал	АШУ-ны доктор
6	Д.Солонго	Гишүүн	АШУҮИС-ийн сувилахуйн сургуулийн тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор
7	Б.Цэнгэлмаа	Гишүүн	СХД-ийн Гурванжаргалхайрхан ӨЭМТ-ийн дарга	АУ-ны доктор
4) Ерөнхий мэс засал судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	О.Сэргэлэн	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	УНТЭ-ийн Мэс заслын тасгийн эрхлэгч	АШУ-ны доктор, профессор, зөвлөх зэргийн эмч
2.	Б.Батсайхан	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн Мэс заслын тэнхимийн багш	АУ-ны доктор
3.	Ж.Адьяасүрэн	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн мэс заслын тасгийн эрхлэгч	АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч
4.	Ү.Санчин	Гишүүн	УХТЭ-ийн Мэс заслын тасгийн эрхлэгч	АУ-ны доктор
5.	Д.Баян-Өндөр	Гишүүн	УНТЭ-ийн Урологийн тасгийн эрхлэгч	АУ-ны доктор
6.	М.Ганбаатар	Гишүүн	УГТЭ-ийн Мэс заслын тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
7.	Ц.Ишдорж	Гишүүн	УНТЭ-ийн Мэс заслын тасгийн эмч	Зөвлөх зэргийн эмч
8.	Ж.Бат-Эрдэнэ	Гишүүн	Цэргийн төв эмнэлгийн Мэс заслын тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
9.	Ц.Энх-Амгалан	Гишүүн	“Интермед” эмнэлгийн Мэс заслын тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
5) Дотрын анагаах судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Х.Алтайсайхан	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУҮИС-ийн Дотрын III тэнхимийн Дотоод шүүрлийн профессорын багийн профессор	АУ-ны доктор, профессор
2.	Н.Ариунцэцэг	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн Дотрын I тэнхимийн ахлах багш	АУ-ны доктор

3.	Т.Ариунаа	Гишүүн	АШУУИС-ийн Дотрын III тэнхимийн Бөөр судлалын профессорын багийн ахлагч	АУ-ны доктор, профессор
4.	О.Баярмаа	Гишүүн	УНТЭ-ийн Гастроэнтерологийн төвийн дарга	АУ-ын доктор
5.	Н.Бира	Гишүүн	АШУУИС-ийн Дотрын II тэнхимийн Хоол боловсруулах эрхтэн судлалын профессорын багийн профессор	АУ-ны доктор
6.	Д.Даваадорж	Гишүүн	АШУУИС-ийн дэд захирал	АУ-ны доктор, дэд профессор
7.	Д.Зулгэрэл	Гишүүн	АШУУИС-ийн Дотрын I тэнхимийн Ревматологийн профессорын багийн ахлагч	АУ-ны доктор, профессор
8.	С.Наранцэцэг	Гишүүн	УГТЭ-ийн эмчилгээ эрхэлсэн захирал	АУ-ны доктор, дэд профессор
9.	С.Өлзийсайхан	Гишүүн	УНТЭ-ийн Уушги судлалын тасгийн эрхлэгч	АУ-ын доктор, клиникийн профессор
10.	Ө.Цолмон	Гишүүн	АШУУИС-ийн Дотрын I тэнхимийн эрхлэгч, Зүрх судлалын профессорын багийн ахлагч	АУ-ны доктор, дэд профессор
11.	А.Энх-Амар	Гишүүн	АШУУИС-ийн Дотрын II тэнхимийн Хоол боловсруулах эрхтэн судлалын тэнхимийн ахлах багш	АУ-ны доктор

6) Дүрс оношилгоо судлалын мэргэжлийн салбар зөвлөл

1.	Б.Эрдэнэбулган	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	ХСҮТ-ийн Дүрс оношилгооны эмч	АУ-ны доктор
2.	Ц.Эрдэмбилэг	Нарийн бичгийн дарга	АШУУИС-ийн Радиологийн тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор
3.	Р.Асай	Гишүүн	ХСҮТ-ийн радиологийн зөвлөх эмч	АУ-ны доктор
4.	Ц.Бадамсэд	Гишүүн	УГТЭ-ийн радиологийн зөвлөх эмч	АУ-ны доктор, профессор
5.	С.Батзориг	Гишүүн	“ЛюксМед” эмнэлгийн радиологийн эмч	Тэргүүлэх зэргийн эмч
6.	З.Лхагвасүрэн	Гишүүн	УГТЭ-ийн Ангиографийн тасгийн эрхлэгч	АУ-ны доктор
7.	Д.Мөнхбаатар	Гишүүн	АШУУИС-ийн Радиологийн тэнхимийн ахлах багш	АУ-ны доктор
8.	П.Төгсжаргал	Гишүүн	АШУУИС-ийн Дүрс оношилгооны тэнхимийн ахлах багш	АУ-ны доктор
9.	Д.Түвшинжаргал	Гишүүн	“УБ, Сонгдо” эмнэлгийн дүрс оношилгооны тасгийн эрхлэгч	АУ-ны доктор

7) Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл				
1.	С.Чимэдцэрэн	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	УНТЭ-ийн лабораторийн эрхлэгч	АУ-ны доктор
2.	Н.Батчимэг	Нарийн бичгийн дарга	АШУУИС-ийн багш	АУ-ны доктор
3.	Б.Баттүвшин	Гишүүн	УГТЭ-ийн Лабораторийн нэгдсэн тасгийн их эмч	АУ-ны доктор
4.	Д.Ганболд	Гишүүн	Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн лавлагаа лабораторийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн тархвар судлаач
5.	Ч.Ганчимэг	Гишүүн	АШУУИС-ийн багш	АУ-ны доктор, дэд профессор
6.	Б.Дармаа	Гишүүн	ХӨСҮТ-ийн Вирусологийн лабораторийн тасгийн эрхлэгч	АУ-ны доктор
7.	Н.Мөнхтүвшин	Гишүүн	Анагаах ухааны хүрээлэнгийн нэгдсэн лабораторийн эрхлэгч	АУ-ны доктор, профессор
8.	Т.Хосбаяр	Гишүүн	АШУУИС-ийн багш	АУ-ны доктор
9.	С.Хишгээ	Гишүүн	“Прецилаб ХХК”-ны захирал	АУ-ны магистр, Клиникийн профессор
8) Мэдрэл судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Д.Өлзийбаяр	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	“Алт-Болд” эмнэлгийн зөвлөх эмч	АУ-ны доктор, дэд профессор
2.	Л.Энхсайхан	Нарийн бичгийн дарга	УНТЭ-ийн Мэдрэлийн эмнэлзүйн төвийн дарга	АУ-ны магистр
3.	П.Алтанцэцэг	Гишүүн	Монголын Мэдрэлийн эмч нарын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал	Тэргүүлэх зэргийн эмч
4.	Р.Амарбаясгалан	Гишүүн	УНТЭ-ийн Мэдрэл судлалын тасгийн зөвлөх эмч	АУ-ны доктор
5.	Ж.Ариунаа	Гишүүн	УГТЭ-ийн харвалтын тасгийн эрхлэгч	АУ-ны магистр, клиникийн профессор, тэргүүлэх зэргийн эмч
6.	Ц.Баясгалан	Гишүүн	АШУУИС-ийн Мэдрэл судлалын тэнхимийн багш	АУ-ны доктор
7.	Ц.Ганзориг	Гишүүн	УХТЭ-ийн Мэдрэл судлалын тасгийн эрхлэгч	Ахлах зэргийн эмч
8.	Л.Отгонбаяр	Гишүүн	АШУУИС-ийн Мэдрэл судлалын тэнхимийн багш	АУ-ны доктор, дэд профессор
9.	Ж.Сарангэрэл	Гишүүн	“Рефлекс” эмнэлгийн захирал, Монголын неврологийн нийгэмлэгийн тэргүүн	АУ-ны доктор

10.	А.Товуудорж	Гишүүн	АШУУИС-ийн судлалын эрхлэгч	Мэдрэл тэнхимийн	АУ-ны доктор, дэд профессор
11.	О.Энхчимэг	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн судлалын тасгийн эрхлэгч	Мэдрэл тэнхимийн	Тэргүүлэх зэргийн эмч

9) Нийгмийн эрүүл мэнд судлалын мэргэжлийн салбар зөвлөл

1.	О.Чимэдсүрэн	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУУИС-ийн эрүүл мэндийн захирал	Нийгмийн сургуулийн	АУ-ны доктор, профессор
2.	Д.Нарансүх	Нарийн бичгийн дарга	АШУУИС-ийн тэнхимийн эрхлэгч	НЭМС-ийн	АУ-ны доктор
3.	Ж.Батжаргал	Гишүүн	НЭМҮТ-ийн Хоол судлалын төвийн дарга		АУ-ны доктор
4.	Б.Баясгалан	Гишүүн	МХЕГ-ын ЭАХХ-ын ахлах байцаагч		НЭМ-ийн магистр
5.	И.Болормаа	Гишүүн	НЭМҮТ-ийн	Эрдэм шинжилгээний ажилтан	АУ-ны доктор
6.	Д.Даваалхам	Гишүүн	АШУУИС-ийн Эдипмиологи, статистикийн эрхлэгч	НЭМС-ийн био тэнхимийн	АУ-ны доктор, дэд профессор
7.	Б.Сувдаа	Гишүүн	НЭМҮТ-ийн	Эрдэм шинжилгээний ажилтан	НЭМ-ийн магистр
8.	Г.Хулан	Гишүүн	НЭМГ-ын НЭМХ-ийн дарга		НЭМ-ийн магистр
9.	Э.Эрдэнэчимэг	Гишүүн	АШУУИС-ийн Орчны эрүүл мэндийн тэнхимийн багш	НЭМС-ийн	АУ-ны доктор, дэд профессор

10) Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл

1.	Т.Булган	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУУИС-ийн Монголын нүдний нарын тэргүүн	багш, нүдний эмч нийгэмлэгийн	АУ-ны доктор, дэд профессор
2.	Ж.Баттуяа	Нарийн бичгийн дарга	УГТЭ-ийн эрхлэгч	Нүдний тасгийн	Клиникийн профессор
3.	Ж.Баасанхүү	Гишүүн	АШУУИС-ийн багш		АУ-ны доктор, профессор
4.	П.Бүрэнжаргал	Гишүүн	УНТЭ-ийн эрхлэгч	Нүдний тасгийн	Клиникийн профессор
5.	Ч.Цэнгэлмаа	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн эрхлэгч	Нүдний мэс заслын тасгийн	АУ-ны магистр
6.	С.Удвал	Гишүүн	Орбита эмнэлгийн эмч	ерөнхий	Тэргүүлэх зэргийн эмч
7.	Д.Уранчимэг	Гишүүн	АШУУИС-ийн багийн ахлагч	профессорын	АУ-ны доктор, дэд профессор
8.	Ч.Чимгээ	Гишүүн	Нүдний эмч	нарын нийгэмлэгийн тэргүүн	АУ-ны магистр
9.	Г.Эрдэнэтуяа	Гишүүн	СХД-ийн эрүүл мэндийн төвийн нүдний эмч		АУ-ны магистр

11) Нүүр ам судлалын мэргэжлийн салбар зөвлөл					
1.	Б.Амарсайхан	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУҮИС-ийн харилцаа, эрдэм хариуцсан дэд захирал	Гадаад шинжилгээ	АУ-ны доктор
2.	Г.Ариунтуул	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн захирал	НАСС-ийн	АУ-ны доктор, дэд профессор
3.	Б.Оюунцэцэг	Гишүүн	АШУҮИС-ийн ХНАСУС-ийн эрхлэгч	НАСС-ийн тэнхимийн	АУ-ны доктор, дэд профессор
4.	Г.Аянга	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Эрүү нүүрний мэс заслын тасгийн эрхлэгч		АУ-ны доктор
5.	Л.Давааням	Гишүүн	АШУҮИС-ийн эрүү нүүрний мэс заслын тэнхимийн багш	НАСС-ийн	АУ-ны доктор, профессор
6.	Т.Ичинхорлоо	Гишүүн	“Энэрэл” эмнэлгийн захирал		АУ-ны магистр, профессор
7.	Б.Отгонбаяр	Гишүүн	АШУҮИС-ийн НАСГЗ-ын эрхлэгч	НАСС-ийн тэнхимийн	АУ-ны доктор
8.	Т.Учрал	Гишүүн	Монголын шүдний холбооны гүйцэтгэх захирал		АУ-ны магистр
9.	М.Энхтайван	Гишүүн	Монголын нүүр амны сувилахуйн нийгэмлэгийн тэргүүн		АУ-ны магистр, докторант
12) Хавдар судлалын мэргэжлийн салбар зөвлөл					
1.	Б.Ганзориг	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	ХСҮТ-ийн Цээжний хөндийн мэс заслын тасгийн эрхлэгч		Клиникийн профессор
2.	М.Адилсайхан	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн судлалын эрхлэгч	Хавдар тэнхимийн	АУ-ны доктор
3.	Г.Байгалмаа	Гишүүн	“Мөнгөн гүүр” эмнэлгийн эмэгтэйчүүдийн мэс заслын асгийн эрхлэгч		АУ-ны доктор
4.	Ц.Гантуяа	Гишүүн	ХСҮТ-ийн эмчилгээний эрхлэгч	Хөнгөвчлөх тасгийн	АУ-ны магистр
5.	М.Минжмаа	Гишүүн	ХСҮТ-ийн эмчилгээний их эмч	Туяа	АУ-ны доктор
6.	Г.Пүрэвдорж	Гишүүн	ХСҮТ-ийн Толгой хүзүүний мэс заслын тасгийн эрхлэгч		АУ-ны доктор
7.	Р.Сандуйжав	Гишүүн	АШУҮИС-ийн судлалын тэнхимийн багш, ХСҮТ-ийн зөвлөх эмч	Хавдар	АУ-ны доктор, профессор
8.	Я.Эрдэнэ-Очир	Гишүүн	ХСҮТ-ийн Мэс заслын клиникийн удирдагч		АУ-ны доктор
9.	Н.Юмчинсэрчин	Гишүүн	ХСҮТ-ийн эмч	Ангиографийн	Ахлах зэргийн эмч

13) Халдварт өвчин, тархвар судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	О.Баатархүү	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУУИС-ийн Халдвартын тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор, профессор
2.	Ч.Мөнхцэцэг	Нарийн бичгийн дарга	ХӨСҮТ-ийн тархвар судлаач, Халдварт өвчинтэй тэмцэх Монголын үндэсний холбооны гүйцэтгэх захирал	АУ-ны доктор
3.	М.Алтанхүү	Гишүүн	Монголын Вирус судлалын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал	АУ-ны доктор
4.	З.Адъяасүрэн	Гишүүн	Монголын тархвар судлаачдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн	АУ-ны доктор
5.	П.Нямдаваа	Гишүүн	ХӨСҮТ-ийн зөвлөх	Академич, АШУ-ны доктор, профессор
6.	М.Оюунгэрэл	Гишүүн	ХӨСҮТ-ийн Чанарын албаны дарга	АУ-ны доктор
7.	Б.Саруул	Гишүүн	ХӨСҮТ-ийн Амбулаторийн эрхлэгч	АУ-ны доктор
8.	Б.Цацралт-Од	Гишүүн	ХӨСҮТ-ийн дэд захирал	АУ-ны доктор
9.	Д.Цэрэнноров	Гишүүн	ЗӨСҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга	АУ-ны доктор
14) БЗДХ/ДОХ-ын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	В.Наранцэцэг	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУУИС-ийн Халдвартын тэнхимийн ахлах багш, Монголын ДОХ-той тэмцэх нийгэмлэгийн гүйцэтгэх захирал	АУ-ны магистр
2.	Ж.Даваалхам	Нарийн бичгийн дарга	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны дарга	АУ-ны доктор
3.	Ч.Бямбаа	Гишүүн	Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн мэргэжилтэн	Клиникийн профессор
4.	Б.Оюунбилэг	Гишүүн	ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны эмч	АУ-ны магистр
5.	С.Цогтсайхан	Гишүүн	АШУУИС-ийн БАС-ийн бичил амь дархлаа судлалын тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор, профессор
6.	Н.Цэнд	Гишүүн	ХӨСҮТ-ийн зөвлөх	АУ-ны доктор, дэд профессор
7.	Ч.Эрдэнэчимэг	Гишүүн	“Төгс бүсгүйчүүд” ТББ-ын эмч	АУ-ны доктор, тэргүүлэх зэргийн эмч
15) Сүрьеэ судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Г.Цогт	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн	АУ-ны доктор



2.	Б.Мөнхзул	Нарийн бичгийн дарга	ХӨСҮТ-ийн сүрьеэгийн клиникийн уушгины I тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
3.	Ч.Баттогтох	Гишүүн	АШУҮИС-ийн БАС, бичил амь дархлаа судлалын тэнхимийн багш	АУ-ны доктор, дэд профессор
4.	Б.Буянхишиг	Гишүүн	ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны зөвлөх	АУ-ны доктор, клиникийн профессор
5.	Н.Наранбат	Гишүүн	Монголын сүрьеэтэй тэмцэх холбооны тэргүүн	АУ-ны доктор, дэд профессор
6.	Д.Наранзул	Гишүүн	ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тархвар судлаач их эмч	АУ-ны доктор
7.	П.Янжиндулам	Гишүүн	ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны дарга	Тэргүүлэх зэргийн эмч
1) Харшил, дархлаа судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	С.Мөнхбаярлах	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУҮИС-ийн Анагаах ухааны сургуулийн захирал	АУ-ны доктор, профессор
2.	Л.Наранцэцэг	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн багш	АУ-ны доктор
3.	Л.Баттөр	Гишүүн	УНТЭ-ийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал	АУ-ны доктор, дэд профессор
4.	Г.Дарамбазар	Гишүүн	АШУҮИС-ийн эмзүй биоанагаахын сургуулийн биологи гистологийн тэнхимийн ахлах багш	АУ-ны доктор
5.	С.Цогтсайхан	Гишүүн	АШУҮИС-ийн БАС-ийн бичил амь дархлаа судлалын тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор, профессор
6.	Н.Раднааханд	Гишүүн	"Астма" эмнэлгийн дарга	АУ-ны доктор, дэд профессор
7.	С.Янжмаа	Гишүүн	АӨСҮТ-ийн поликлиникийн тасгийн эмч	АУ-ны магистр
2) Хор судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	С.Юндэн	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	"Гэгээ Мед" эмнэлгийн зөвлөх эмч	АУ-ны доктор, профессор
2.	Р.Даваадорж	Нарийн бичгийн дарга	НЭМҮТ-ийн ОЭМХСТ-ийн Эмнэлзүйн хор судлалын эрдэм шинжилгээний ажилтан	АУ-ны магистр
3.	О.Баяр	Гишүүн	Шинэ анагаах ухаан дээд сургуулийн багш	АУ-ны магистр

4.	Ч.Гүрбазар	Гишүүн	Хордлогын тусламжийн төвийн дарга	яаралтай үндэсний	АУ-ны магистр
5.	Ш.Мөнхтулга	Гишүүн	ОБЕГ-ын ГШУГ-ын химийн хорт бодис, бактерлоги, цацрагийн аюултай тэмцэх асуудал хариуцсан мэргэжилтэн		Химийн ухааны магистр
6.	Д.Оролзод	Гишүүн	Хордлогын тусламжийн төвийн тасгийн эрхлэгч	яаралтай үндэсний эмчилгээний	АУ-ны магистр
7.	Ц.Оюу	Гишүүн	НЭМҮТ-ийн Эмнэлзүйн эрдэм ажилтан	ОЭМХСТ-ийн хор судлалын шинжилгээний	ШУ-ны магистр
8.	С.Өнөрсайхан	Гишүүн	НЭМҮТ-ийн Эмнэлзүйн эрдэм ахлах ажилтан	ОЭМХСТ-ийн хор судлалын шинжилгээний	Химийн ухааны доктор, дэд профессор
9.	Ш.Паламдорж	Гишүүн	Батлан хамгаалахын хүрээлэнгийн шинжилгээний эрдэм тэргүүлэх ажилтан		ШУ-ны доктор, профессор

18) Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл

1.	Б.Баясгалантай	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУҮИС-ийн анагаахын тэнхимийн	Хүүхдийн багш	АУ-ны доктор
2.	Т.Болормаа	Нарийн бичгийн дарга	ЭХЭМҮТ-ийн тасгийн эрхлэгч	Зүрх, судасны	АУ-ны доктор
3.	Д.Агиймаа	Гишүүн	АШУҮИС-ийн анагаахын эрхлэгч	Хүүхдийн тэнхимийн	АУ-ны доктор
4.	Ц.Алтантуяа	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн эмнэлгийн захирал	Хүүхдийн	АШУ-ны магистр
5.	П.Отгонбаяр	Гишүүн	“Бүүвэй ээж” хүүхдийн мэдрэлийн эмч	эмнэлгийн зөвлөх	АУ-ны доктор
6.	Д.Гэрэлмаа	Гишүүн	“Интермед” Хүүхдийн тасгийн эрхлэгч	эмнэлгийн	Клиникийн профессор
7.	Д.Даваасүрэн	Гишүүн	“Энх-Ирээдүй” эмнэлгийн ерөнхий эмч	хүүхдийн	АУ-ны доктор, дэд профессор
8.	Д.Малчинхүү	Гишүүн	АШУҮИС-ийн анагаахын тэнхимийн багш	Хүүхдийн	АУ-ны доктор, профессор
9.	А.Оюунчимэг	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн тусламж чанарын албаны дарга	Эмнэлгийн үйлчилгээ,	АУ-ны магистр
10.	Н.Ууганцэцэг	Гишүүн	Хөгжлийн хүүхэдтэй холбоо, хүүхэд төвийн менежер	бэрхшээлтэй эцэх эхийг	АУ-ны магистр
11.	Г.Эрдэнэтуяа	Гишүүн	АШУҮИС-ийн анагаахын тэнхимийн багш	Хүүхдийн	АУ-ны доктор, дэд профессор

19) Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Н.Наранбаатар	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУУИС-ийн Сувилахуйн сургуулийн захирал	АУ-ны доктор
2.	Б.Төмөрчөдөр	Нарийн бичгийн дарга	УНТЭ-ийн сургалт мэргэжилтэн	Сувилахуйн хариуцсан Сувилахуйн ухааны магистр
3.	Г.Ганхуяг	Гишүүн	АШУУИС-ийн сургуулийн сувилахуйн эрхлэгч	Сувилахуйн Суурь ухааны доктор тэнхимийн
4.	О.Казил	Гишүүн	Улаанбаатар их сургуулийн Сувилахуйн сургуулийн захирал	Сувилахуйн ухааны доктор, профессор
5.	Ж.Мөнхханд	Гишүүн	АШУУИС-ийн сувилахуйн эрхлэгч	Суурь АУ-ны магистр тэнхимийн
6.	Д.Нямсүрэн	Гишүүн	УХТЭ-ийн албаны дарга	Сувилахуйн ухааны магистр
7.	С.Оюунцэцэг	Гишүүн	АШУУИС-ийн төгсөлтийн өмнөх сургалтын албаны дарга	Сувилахуйн ухааны доктор
8.	Д.Пүрэвдаваа	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн албаны дарга	Сувилахуйн ухааны магистр
9.	Л.Хишигдэлгэр	Гишүүн	Сувилахуйн сургуулийн эх хүүхдийн тэнхимийн багш	Сувилахуйн ухааны магистр
20) Сэргээн засал судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	А.Балжинням	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУУИС-ийн Гэмтэл согог сэргээн засахын тэнхимийн багш, ББСЗСМН-ийн зөвлөх	АУ-ны доктор, дэд профессор
2.	Г.Намуун	Нарийн бичгийн дарга	АШУУИС-ийн Хөдөлгөөн заслын тэнхимийн багш, МББХЗХ-ны удирдах зөвлөлийн гишүүн	АУ-ны магистр
3.	О.Амаржаргал	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн ЭБЭ-ийн эмнэлгийн сэргээн засах тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
4.	О.Батгэрэл	Гишүүн	УГТЭ-ийн Эрдэм шинжилгээ, сургалт, хамтын ажиллагаа хариуцсан орлогч дарга	АУ-ны доктор
5.	О.Золзаяа	Гишүүн	УХТЭ-ийн Сэргээн засах эмчилгээний тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
6.	П.Отгонгэрэл	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн хүний нөөцийн албаны дарга	Клиникийн профессор
7.	Г.Туяа	Гишүүн	Рашаан судлалын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал	АУ-ны магистр
8.	Д.Цэнджав	Гишүүн	НЭМГ-ийн сэргээн засах, шинжлэх ухаан хариуцсан мэргэжилтэн	АУ-ны доктор

9.	Ц.Цэнгэлмаа	Гишүүн	ХСҮТ-ийн сэргээн засах эмчилгээний тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
21) Сэтгэц судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	З.Хишигсүрэн	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУҮИС-ийн АУС-ийн СЭМ-ийн тэнхимийн багш	АУ-ны доктор, профессор
2.	Т.Ганцэцэг	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн АУС-ийн СЭМ-ийн тэнхимийн багш	АУ-ны доктор
3.	О.Ганчулуун	Гишүүн	СЭМҮТ-ийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал	Тэргүүлэх зэргийн эмч
4.	Д.Лянхуа	Гишүүн	СЭМҮТ-ийн шүүхийн сэтгэцийн эмгэг судлаач эмч	Тэргүүлэх зэргийн эмч
5.	Б.Одонтуяа	Гишүүн	АШУҮИС-ийн Өрхийн анагаах ухааны тэнхимийн багш	АУ-ны доктор
6.	Н.Оюунчимэг	Гишүүн	СЭМҮТ-ийн чанарын албаны дарга	АУ-ны магистр
7.	Н.Туяа	Гишүүн	Сэтгэцийн эрүүл мэндийн нийгэмлэгийн тэргүүн	АУ-ны магистр
8.	Л.Эрдэнэбаяр	Гишүүн	СЭМҮТ-ийн зөвлөх эмч	АШУ-ны доктор, профессор, академич
9.	М.Эрдэнэтуяа	Гишүүн	АШУҮИС-ийн ЭЗБАС Эмнэлзүйн эм зүй, зохион байгуулалтын тэнхимийн багш	АУ-ны доктор, дэд профессор
22) Удамзүй судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	И.Пүрэвдорж	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУҮИС-ийн Удамзүйн тэнхимийн багш	АУ-ны доктор
2.	Д.Ангармөрөн	Нарийн бичгийн дарга	АШУҮИС-ийн НЭМС-ийн багш	АУ-ны доктор
3.	В.Баярмаа	Гишүүн	СЭМҮТ-ийн Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал	АУ-ны магистр
4.	О.Дуламсүрэн	Гишүүн	ХСҮТ-ийн биоанагаахын мэргэжилтэн	АУ-ны доктор
5.	Ж.Жамбалдорж	Гишүүн	АШУҮИС-ийн багш	АУ-ны доктор
6.	Б.Мөнхбат	Гишүүн	Анагаах ухааны хүрээлэнгийн орлогч захирал	АШУ-ны доктор, профессор
7.	Г.Мэндсайхан	Гишүүн	АШУҮИС-ийн ЭБЭ-ийн тэнхимийн багш	АУ-ны доктор, дэд профессор
8.	Ө.Оюунчимэг	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн анагаахын удам зүйн лабораторийн эрхлэгч	АУ-ны доктор
9.	Д.Энхмаа	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн эмбрологич	АУ-ны доктор

23) Уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	З.Мэндсайхан	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	Монголын эмнэлгүүдийн захирал	хувийн холбооны АУ-ны доктор
2.	Ж.Тогтохбаяр	Нарийн бичгийн дарга	ЭМХТ-ийн мэргэжилтний албаны дарга	Эмнэлгийн хөгжлийн АУ-ны доктор
3.	М.Амбага	Гишүүн	Шинэ анагаах ухаан дээд сургуулийн захирал	АШУ-ны доктор, профессор
4.	Ш.Болд	Гишүүн	Монос эмзүйн их сургуулийн УАУ-ны сургуулийн захирал	Академич, АУ-ны доктор, профессор
5.	Д.Ганзориг	Гишүүн	"Найдан" эмнэлгийн захирал	АУ-ны магистр
6.	Д.Нацагдорж	Гишүүн	Монголын уламжлалт эмнэлэг, сургалтын төвийн захирал	АУ-ны доктор
7.	Д.Цэрэндагва	Гишүүн	Монгол анагаах ухаан олон улсын сургуулийн захирал	Академич, АУ-ны доктор, профессор
8.	С.Цээсрэгдорж	Гишүүн	Монгол анагаах ухаан олон улсын сургуулийн багш	АУ-ны доктор, профессор
9.	Ч.Чимэдрагчаа	Гишүүн	Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн захирал	АУ-ны доктор, профессор
24) Уролог, андролог судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Д. Нямсүрэн	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	УНТЭ-ийн УАТ болон Бөөр шилжүүлэн суулгах багийн зөвлөх эмч	АУ-ны доктор, профессор
2.	Г.Ганболд	Нарийн бичгийн дарга	УНТЭ-ийн УАТ-ийн их эмч	АУ-ны магистр
3.	Д.Баян-Өндөр	Гишүүн	УНТЭ-ийн Урологийн тасгийн эрхлэгч	АУ-ны доктор
4.	Н.Нансалмаа	Гишүүн	"АДАМ" эмнэлгийн эмч	АУ-ны доктор
5.	М.Мөнхжаргал	Гишүүн	"Сонгдо" эмнэлгийн эмч	АУ-ны магистр
6.	М.Пүрэвтогтох	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Үргүйдэл нөхөн үржихүйн төвийн эрхлэгч	ШУ-ны магистр
7.	Б.Энхравдан	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн урологийн тасгийн зөвлөх эмч	Тэргүүлэх зэргийн эмч
25) Цус судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Н.Оюундэлгэр	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	УНТЭ-ийн ЦЭСЧШСТ-ийн дарга	АУ-ны магистр
2.	Т.Алимаа	Нарийн бичгийн дарга	ЦССҮТ-ийн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
3.	Ч.Дэлгэрцэцэг	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Цусны эмгэг судлалын тасгийн эрхлэгч	АУ-ны магистр

4.	Ц.Одгэрэл	Гишүүн	АШУУИС-ийн АУС-ийн Цусны эмгэг судлалын профессорын багийн ахлагч	АУ-ны магистр, дэд профессор
5.	Ц.Тунгалагтамир	Гишүүн	ЦССҮТ-ийн технологич эмч	НЭМ-ийн магистр
6.	Б.Хишигжаргал	Гишүүн	УНТЭ-ийн ЦЭСЧШСТ-ийн эмч	АУ-ны магистр
7.	Л.Энхсайхан	Гишүүн	АШУУИС-ийн ЭЗ-БАС-ийн Дархлаа судлалын тэнхмийн багш	АУ-ны доктор
26) Цээжний хөндийн мэс засал судлалын салбар зөвлөл				
1.	Н.Баасанжав	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	“Ач” анагаах ухааны дээд сургуулийн захирал	Академич, АШУ-ны доктор, профессор
2.	Л.Амгалан	Нарийн бичгийн дарга	УНТЭ-ийн Мэс заслын тасгийн эрхлэгч	АУ-ны доктор
3.	Д.Бат-Ундрал	Гишүүн	УГТЭ-ийн Зүрхний мэс заслын тасгийн их эмч	АУ-ны магистр
4.	О.Ганбат	Гишүүн	УНТЭ-ийн Мэс заслын тасгийн эмч	Зөвлөх зэргийн эмч
5.	Ц.Нармандах	Гишүүн	УХТЭ-ийн Мэс заслын зөвлөх эмч	АУ-ны магистр
6.	Ц.Рэнцэнмягмар	Гишүүн	ХӨСҮТ-ийн Мэс заслын зөвлөх эмч	Тэргүүлэх зэргийн эмч
7.	М.Түмэннасан	Гишүүн	“Гурван гал” эмнэлгийн зөвлөх эмч	АУ-ны доктор
27) Чих, хамар, хоолой судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Э.Жаргалхүү	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУУИС-ийн Чих, хамар, хоолой, нүд судлалын тэнхимийн багш	АУ-ны доктор
2.	С.Бямбасүрэн	Нарийн бичгийн дарга	УГТЭ-ийн Чих, хамар, хоолойн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
3.	Д.Арьяамаа	Гишүүн	УНТЭ-ийн Чих, хамар, хоолойн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
4.	Л.Бямбасүрэн	Гишүүн	Монголын чих, хамар, хоолойн эмч нарын нийгэмлэгийн тэргүүн	АУ-ны доктор
5.	П.Ганчимэг	Гишүүн	АШУУИС-ийн Чих хамар хоолой, нүд судлалын тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор
6.	Б.Дэлгэрмаа	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Чих, хамар, хоолойн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
7.	Д.Чулуунбаатар	Гишүүн	УХТЭ-ийн Чих, хамар, хоолойн тасгийн эрхлэгч	Ахлах зэргийн эмч
28) Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Ш.Энхтуяа	Ерөнхий мэргэжилтэн	Эмгэг судлалын үндэсний төвийн зөвлөх эмгэг судлаач	АУ-ны доктор

		бөгөөд салбар зөвлөлийн дарга	судлаач	
2.	Э.Баярмаа	Нарийн бичгийн дарга	АШУУИС-ийн ЭЗ-БАС-ийн Эмгэг бүтэц үйл судлалын тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор, дэд профессор
3.	Л.Галцог	Гишүүн	АШУУИС-ийн ЭЗ-БАС-ийн Эмгэг бүтэц үйл судлалын тэнхимийн зөвлөх профессор	АУ-ны доктор, профессор
4.	Б.Оюун-Эрдэнэ	Гишүүн	Интермед эмнэлгийн эмгэг судлаач	АУ-ны магистр
5.	Б.Туул	Гишүүн	АШУУИС-ийн ЭЗ-БАС-ийн Эмгэг бүтэц үйл судлалын тэнхимийн ахлах багш	АУ-ны магистр
6.	С.Түндэврэнцэн	Гишүүн	АШУУИС-ийн Анатомян тэнхимийн багш	АУ-ны доктор, профессор
7.	Б.Уранчимэг	Гишүүн	Эмгэг судлалын үндэсний төвийн зөвлөх эмгэг судлаач	АУ-ны магистр
29) Эм зүй, эм судлалын мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Д.Энхжаргал	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУУИС-ийн ЭЗБАС-ийн Эмийн хими, ургамал судлал, технологийн тэнхимийн багш	АУ-ны доктор, профессор
2.	Х.Даариймаа	Нарийн бичгийн дарга	АШУУИС-ийн ЭЗБАС-ийн Эмийн хими, ургамал судлал, технологийн тэнхимийн багш	ЭЗУ-ны доктор
3.	П.Батхуяг	Гишүүн	АШУУИС-ийн Эм судлалын тэнхимийн багш	АУ-ны доктор, профессор
4.	Д.Жамбанинж	Гишүүн	АШУУИС-ийн ЭЗБАС-ийн эм судлалын тэнхимийн багш	ЭЗУ-ны доктор
5.	Ч.Ерөөлт	Гишүүн	АШУУИС-ийн ЭЗБАС эм судлалын тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор
6.	Ж.Оюунбилэг	Гишүүн	НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан	ШУ-ны доктор
7.	О.Уранчимэг	Гишүүн	ХСҮТ-ийн эмнэлзүйн албаны дарга	ЭЗУ-ны доктор
8.	Р.Мөнхцэцэг	Гишүүн	Цомбо ХХК-ний захирал	ЭЗУ-ны доктор
9.	Д.Цэндээхүү	Гишүүн	Монголын эм хангамжийн ажилтны ерөнхийлөгч ХХК захирал	ЗЗШУ-ны доктор
10.	С.Цэцэгмаа	Гишүүн	Азийн хөгжлийн банкны зөвлөх	АУ-ны доктор, профессор
11.	Д.Энхмаа	Гишүүн	АШУУИС-ийн Химийн тэнхимийн багш	Химийн ухааны доктор, дэд профессор

30) Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжлийн салбар зөвлөл				
1.	Б.Энхжаргал	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	ШУТИС-ийн Эрчим хүчний сургуулийн багш	Техникийн ухааны доктор, дэд профессор, Монгол улсын Эмнэлгийн техникийн зөвлөх инженер
2.	Р.Даваасүрэн	Нарийн бичгийн дарга	ЭХЭМҮТ-ийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн тасгийн инженер	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэшсэн инженер
3.	Б.Батцэнгэл	Гишүүн	ЭМХТ-ийн Мэдээллийн технологи, эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны мэргэжилтэн	Техникийн ухааны магистр, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэшсэн инженер
4.	М.Бат-Эрдэнэ	Гишүүн	Монголын эмнэлгийн инженерүүдийн нийгэмлэгийн нарийн бичгийн дарга	Техникийн ухааны магистр, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер
5.	Ж.Баярмаа	Гишүүн	МХЕГ-ын улсын ахлах байцаагч	Физикийн ухааны доктор
6.	Ж.Ганбат	Гишүүн	УНТЭ-ийн Эмнэлгийн техникийн албаны зөвлөх инженер	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэргэшсэн инженер
7.	Х.Хүрэлчулуун	Гишүүн	ГССҮТ-ийн Инженер технологийн албаны зөвлөх инженер	Монгол улсын Эмнэлгийн техникийн зөвлөх инженер
31) Эрүүл мэндийн удирдлага, эдийн засгийн салбар зөвлөл				
1.	Ц.Содномпил	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АХБ-ны төслийн зохицуулагч	АУ-ны доктор
2.	Г.Баянжаргал	Нарийн бичгийн дарга	Эрүүл мэндийн удирдах ажилтны нийгэмлэгийн гүйцэтгэх захирал	Удирдахуйн ухааны магистр
3.	С.Батсүх	Гишүүн	Удирдлагын академийн дэд захирал	Удирдахуйн ухааны доктор

4.	Б.Булганчимэг	Гишүүн	"Эрүүл мэндийн салбар хөгжил-5" төслийн менежер	Эмнэлгийн удирдлагын магистр
5.	Ю.Гантөгс	Гишүүн	АШУУИС-ийн НЭМС-ийн Эрүүл мэндийн бодлого менежментийн тэнхимийн ахлах багш	Эрүүл мэндийн эдийн засгийн магистр, НЭМ-ийн доктор
6.	С.Дуламсүрэн	Гишүүн	"Шинэ нийгмийн эрүүл мэнд" ТББ-ын тэргүүн	АУ-ны доктор
7.	Л.Мөнх-Эрдэнэ	Гишүүн	АШУУИС-ийн НЭМС-ийн Эрүүл мэндийн удирдлагын тэнхимийн эрхлэгч	АУ-ны доктор
8.	Ц.Цолмонгэрэл	Гишүүн	Эрүүл мэндийн эдийн засагч, судлаач	Эдийн засгийн ухааны магистр
9.	Д.Чимэддагва	Гишүүн	"Макро эдийн засаг ба эрүүл мэнд" ТББ-ын тэргүүн	Эдийн засгийн ухааны магистр
10.	Н.Хүрэлбаатар	Гишүүн	Монгол Мэдлэг Академийн зөвлөх	АУ-ны доктор
11.	Э.Эрдэнэчимэг	Гишүүн	ДЭМБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын Эрүүл мэндийн тогтолцоо, санхүүжилт хариуцсан мэргэжилтэн	Эрүүл мэндийн эдийн засгийн магистр, НЭМ-ийн магистр

32) Эрчимт эмчилгээ судлалын мэргэжлийн салбар зөвлөл

1.	Л.Ганболд	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУУИС-ийн тусламжийн эрхлэгч	АУ-ны доктор, дэд профессор
2.	Л.Өнөрзаяа	Нарийн бичгийн дарга	УНТЭ-ийн мэдээгүйжүүлгийн тасгийн эмч	АУ-ны магистр Тэргүүлэх зэргийн эмч
3.	М.Ариунтунгалаг	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн мэс заслын клиникийн мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч	Тэргүүлэх зэргийн эмч
4.	Р.Баянмөнх	Гишүүн	БХХСАХНЭ-ийн мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч	АУ-ны магистр
5.	Ц.Ганбат	Гишүүн	УНТЭ-ийн Эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэг яаралтай тусламжийн нэгдсэн төвийн зөвлөх эмч	АУ-ны магистр Зөвлөх зэргийн эмч
6.	Л.Оюунтунгалаг	Гишүүн	"Мөнгөн гүүр" эмнэлгийн эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн тасгийн их эмч	АУ-ны магистр
7.	Х.Урангоо	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн Эх барихын клиникийн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч	АУ-ны магистр Тэргүүлэх зэргийн эмч
8.	А.Эрдэнэдалай	Гишүүн	УГТЭ-ийн мэдээгүйжүүлгийн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр Тэргүүлэх зэргийн эмч

9.	Т.Эрдэнэчимэг	Гишүүн	“Интермед” Хүүхдийн эмчилгээний эмч	эмнэлгийн эрчимт	АУ-ны магистр Тэргүүлэх зэргийн эмч
33) Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл					
1.	Б.Мөнхцэцэг	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	АШУУИС-ийн тэнхимийн эрхлэгч	ЭБЭ-ийн	АУ-ны доктор
2.	Ж.Энхцэцэг	Нарийн бичгийн дарга	АШУУИС-ийн тэнхимийн ахлах багш	ЭБЭС-ийн	АУ-ны доктор
3.	Г.Баттулга	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн эмчилгээ эрхэлсэн захирал	ЭБЭЭ-ийн	АУ-ны доктор Тэргүүлэх зэргийн эмч
4.	Ч.Мөнхбаяр	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн эмэгтэйчүүдийн эмгэгийн тасгийн эрхлэгч		АУ-ны магистр, Тэргүүлэх зэргийн эмч
5.	Б.Оюунгэрэл	Гишүүн	“Үйлс бүтэмж” эмнэлгийн эх баригч		Зөвлөх зэргийн эх баригч ЭХ-ын гавьяат ажилтан
6.	Б.Цэдмаа	Гишүүн	НҮБ-ХАС-ийн “Эх нярайн тусламжид зайн оношилгооны дэмжлэг үзүүлэх” төслийн зохицуулагч		АУ-ны магистр Тэргүүлэх зэргийн эмч
7.	С.Хишгээ	Гишүүн	ЭХЭМҮТ-ийн зөвлөх эмч	ЭБЭЭ-ийн	АУ-ны доктор Зөвлөх зэргийн эмч
8.	Т.Эрхэмбаатар	Гишүүн	АШУУИС-ийн тэнхимийн ахлах багш	ЭБЭС-ийн	АШУ-ны доктор, профессор
9.	Д.Янжинсүрэн	Гишүүн	АШУУИС-ийн тэнхимийн ахлах багш	ЭБЭС-ийн	АУ-ны доктор, дэд профессор
34) Яаралтай тусламж судлалын мэргэжлийн салбар зөвлөл					
1.	О.Оюунбилэг	Ерөнхий мэргэжилтэн бөгөөд салбар зөвлөлийн дарга	Шинэ анагаах ухаан дээд сургуулийн эрхлэгч	тэнхимийн	АУ-ны доктор, профессор
2.	Э.Батжаргал	Нарийн бичгийн дарга	ЭМХТ-ийн тусламжийн хариуцсан мэргэжилтэн	Яаралтай асуудал	АУ-ны магистр
3.	С.Ариунболд	Гишүүн	Нийслэлийн тусламжийн төвийн дэд дарга	түргэн	АУ-ны магистр
4.	Б.Батсүх	Гишүүн	ХӨСҮТ-ийн тусламжийн тасгийн эрхлэгч	Яаралтай	АУ-ны магистр
5.	Ө.Билгүүн	Гишүүн	АШУУИС-ийн тусламжийн тэнхимийн ахлах багш	Яаралтай	АУ-ны доктор
6.	М.Наранпүрэв	Гишүүн	“Интермед” Яаралтай тасгийн эмч	эмнэлгийн тусламжийн	АУ-ны доктор

7.	Д.Санжаа	Гишүүн	УХТЭ-ийн тусламжийн эрхлэгч	Яаралтай тасгийн	АУ-ны магистр
8.	Н.Тосонхүү	Гишүүн	Цэргийн төв эмнэлгийн Хорлогын яаралтай тусламжийн тувийн эмч		АУ-ны магистр
9.	Р.Энхсайхан	Гишүүн	ГССҮТ-ийн эмчилгээ болон яаралтай тусламж эрхэлсэн дэд захирал		АУ-ны доктор
10.	Д.Нарантуяа	Гишүүн	УГТЭ-ийн Харвалт, зүрхний шигдээсийн төвийн зөвлөх эмч		АУ-ны доктор
11.	С.Янжмаа	Гишүүн	АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн ахлах багш		АУ-ны магистр

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 01 сарын 02-ны өдрийн
А/1 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөл /цаашид зөвлөл гэх/ нь эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, тухайн мэргэжлийн чиглэлээр бодлогын төсөлд санал өгөх, удирдамж боловсруулах, цаг үеийн тулгамдсан асуудлаар яамны холбогдох газар, хэлтэстэй зөвшилцөн, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах, хамтарч ажиллах чиг үүрэгтэй.

1.2 Мэргэжлийн салбар зөвлөл нь ерөнхий мэргэжилтэн, нарийн бичгийн дарга болон салбар зөвлөлийн гишүүдээс бүрдэнэ.

1.3 Мэргэжлийн салбар зөвлөл нь журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

1.4 Ерөнхий мэргэжилтэн болон салбар зөвлөлийн дарга, мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүдийг дараах тохиолдолд чөлөөлнө:

1.4.1 Өөрөө хүсэлтээ гаргасан,

1.4.2 Эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар нэг жилээс дээш хугацаагаар үүрэгт ажлаа гүйцэтгээгүй бол,

1.4.3 Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргасан нь нотлогдсон,

1.4.4 Эрүүгийн хэрэг үйлдсэн нь нотлогдсон,

Хоёр. Мэргэжлийн салбар зөвлөлийн ажлын чиг үүрэг

2.1 Зөвлөл нь тухайн мэргэжлийн чиглэлийн нийгэмлэг, холбоодын тэргүүн, эрүүл мэндийн байгууллагын тэргүүлэх мэргэжилтнүүдээс бүрдсэн 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх ба зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайд баталгаажуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулна;

2.2 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Гишүүдийн олонхи буюу 75 хувийн ирцтэй тохиолдолд мэргэжлийн зөвлөлийн хурлыг хүчинтэйд тооцно;

2.3 Зөвлөл нь сард 1-ээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд зөвлөлийн даргын шийдвэрээр хуралдаж болно;

2.4 Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаараа шийдвэр гаргана. Шийдвэр нь тухайн хэлэлцсэн асуудалтай холбоотой санал, дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна. Шийдвэрийг ерөнхий мэргэжилтэн гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчинтэйд тооцож, холбогдох байгууллагад хүргүүлнэ;

2.5 Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох шалгалтыг зохион байгуулж буй бусад холбогдох байгууллагад мэргэжлийн дэмжлэг, тусалцаа үзүүлнэ;

2.6 Холбогдох асуудлаар иргэд, албан тушаалтан, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, бусад материалыг судлан мэргэжлийн санал, дүгнэлт гаргана;

2.7 Улс оронд аюул, гамшгийн байдал тохиолдоход мэргэжлийн чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлон, хэрэгжилтэд биечлэн оролцоно;

2.8 Зөвлөлийн гишүүд нь хуралд санал өгөх эрхтэй оролцож, мэргэжлийн зөвлөлийг төлөөлж ажлын хэсэгт орж ажиллах, эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинэ санаа, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх талаар санал дэвшүүлж мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, хэрэгжилтэд биечлэн оролцох, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын үйл ажиллагааг уялдуулах, гадаад дотоодын нийгэмлэг, холбоодын туршлагыг өөрийн оронд нэвтрүүлэх, холбогдох шийдвэр гаргахад Эрүүл мэндийн яамтай хамтран ажиллана;

2.9 Эрүүл мэндийн яамнаас зохиогдож буй хурал, чуулганыг зохион байгуулахад оролцоно;

2.10 Эрүүл мэндийн яамнаас тухайн мэргэжлийн чиглэлээр зохион байгуулах сургалтыг холбогдох газар, хэлтэс, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулна;

2.11 Зөвлөл нь ашгийн төлөө ямар нэг үйл ажиллагаа зохион байгуулахгүй.

Гурав. Ерөнхий мэргэжилтний ажлын чиг үүрэг

3.1 Тухайн чиглэлээр салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгох асуудлаар боловсруулсан баримт бичигт санал өгч, бодлого, стратегийн чиглэлийн хэрэгжилтийг хангахад мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө өгнө;

3.2 Эрүүл мэндийн яамны газар, хэлтэс, мэргэжилтнүүдтэй мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллана;

3.3 Ерөнхий мэргэжилтэн нь тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг яамны асуудал хариуцсан мэргэжилтэнтэй зөвшилцөн, эмнэлгийн тусламжийн газраар хянуулж, жил бүрийн 1 дүгээр сард багтаан Эрүүл мэндийн сайдаар батлуулж хэрэгжүүлнэ;

3.4 Ерөнхий мэргэжилтэн нь санаачлан зохион байгуулах үйл ажиллагаа болон яам төлөөлсөн арга хэмжээнд оролцохдоо яамны холбогдох газар, хэлтэст урьдчилан танилцуулна;

3.5 Ерөнхий мэргэжилтэн нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга болон яамны газар, хэлтсийн захиалгаар мэргэжлийн чиглэлээрх ажлыг гүйцэтгэнэ;

3.6 Ерөнхий мэргэжилтэн нь тухайн хэлэлцэж буй асуудалд холбогдох мэргэжлийн нийгэмлэг, холбоодын дарга, тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүдийг татан оролцуулж, санал авна;

3.7 Мэргэжлийн чиглэлээр тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал, зөвлөмж өгч, дүгнэлт гаргахад оролцоно;

3.8 Мэргэжлийн чиглэлээр оношилгоо, эмчилгээ, сувилахуй, тандалтын стандарт, эмнэлзүйн заавар, сурах бичиг, гарын авлага, хяналтын хуудас боловсруулах, хянан тохиолдуулахад оролцоно;

3.9 Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг сайжруулах, тухайн мэргэжлийн онцлогийг тусгасан ёс зүйн өвөрмөц хэм хэмжээг боловсруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм, хэмжээг мөрдүүлэх талаар санаачилгатай ажиллана;

3.10 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөр, мэргэжлийн боловсролын стандарт боловсруулах, мэргэжлийн индексийг боловсронгуй болгоход оролцоно;

3.11 Нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжлийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, санал өгнө;

3.12 Тухайн мэргэжлийн чиглэлээр яаманд иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд оролцох, санал өгөх, газар дээр нь очиж хянаж үнэлэх, дүгнэлт гаргахад оролцоно.

Дөрөв. Нарийн бичгийн даргын ажлын чиг үүрэг

4.1 Ерөнхий мэргэжилтний зааварчилгаагаар салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой албан бичгийг боловсруулна;

4.2 Зөвлөлийн хурал зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах, хурлын тэмдэглэлийг хөтлөх, хурлаар хэлэлцэх асуудлын материалыг бэлтгэнэ;

4.3 Мэргэжлийн салбар зөвлөлийн жил бүрийн үйл ажиллагаатай холбоотой албан бичиг, хурлын тэмдэглэл, санал, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох зааврын дагуу архивын нэгж болгон бүрдүүлж, Эрүүл мэндийн яамны архивт шилжүүлнэ.

--ooOoo--